



ДАРХАН-УУЛ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 01-5/17

Дархан

Буяндалайн Эрдэнэтулгыг ажилд  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, 27.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6, Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох тухай журам", 2022 оны 487 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай", 2023 оны 241 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай", Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2024 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дархан-Уул аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн Буяндалайн Эрдэнэтулгыг Авлигатай тэмцэх газрын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 05/3014 дугаартай албан бичигт ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй байх тул 2024 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн аймгийн Эрүүл мэндийн газрын даргын албан тушаалд томилсугай.

2. Ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:

Б.Энхцэцэг  
Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
(АЗДТГ)-ын Нийгмийн бодлогын хэлтсийн  
ахлах мэргэжилтэн

Гишүүд:

Г.Байгальмаа  
(АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн  
мэргэжилтэн)

Б.Эрдэнэчимэг  
(Эрүүл мэндийн газрын Удирдлага, төлөвлөлт,  
санхүүгийн хэлтсийн дарга)

Б.Жаргалмаа  
(Эрүүл мэндийн газрын хүний нөөцийн  
мэргэжилтэн)

D: ZDTG-2024 zahiramj

4524010311

Ж.Баярзаяа  
(Эрүүл мэндийн газрын бичиг хэрэг, даргын  
туслах)

3.Б.Эрдэнэтулгын цалинг төрийн захиргааны албан тушаалын зэрэглэлийн ТЗ-4 дэх цалингийн хэмжээгээр 1,757,000 (нэг сая долоон зуун тавин долоон мянга) төгрөгөөр тогтоож, төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 25 хувиар, орон нутгийн нэмэгдэл болон холбогдох бусад нэмэгдэл, урамшууллыг хууль тогтоомжийн дагуу тооцож олгохыг Эрүүл мэндийн газрын нягтлан бодогч (Б.Эрдэнэчимэг)-д зөвшөөрсүгэй.

4.Б.Эрдэнэтулгын үүрэгт ажлыг 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн дотор зохих журмын дагуу хүлээлцүүлж, тайлагнахыг ажлын хэсгийн дарга (Б.Энхцэцэг)-д үүрэг болгосугай.

5.Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг 30 хоногийн дотор эрх бүхий албан тушаалтанд мэдүүлэхийг Б.Эрдэнэтулгад үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АСЖАРГАЛ